

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТУХАЙ**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь дотоодын эрэлтэд тулгуурласан, экспортод чиглэсэн, өрсөлдөх чадвартай, үнэ цэнэ шингэсэн, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хууль тогтоомж

2.1. Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай, Технологи дамжуулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль болон бусад хууль эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1 Энэ хууль нь хөнгөн үйлдвэрлэлийн асуудлыг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг зохицуулна.

3.2 Энэ хуульд уул уурхай, хүнд үйлдвэрлэл хамаарахгүй.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1 “боловсруулалт” гэж зориулалтын тоног төхөөрөмж, технологийн шугамыг ашиглан түүхий эдийг бүтээгдэхүүн, эсхүл дараагийн шатны үйлдвэрлэлийн материалд хувиргах үйл явцыг;

4.1.2 “хөнгөн үйлдвэрлэл” гэж түүхий эд, хагас боловсруулсан материалыг хэрэглэгчдэд чиглэсэн үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийн үйл ажиллагааг;

4.1.3 "тогтвортой үйлдвэрлэл" гэж эрчим хүч, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглан хүрээлэн буй орчин, нийгэмд ээлтэй, эдийн засгийн хувьд ашигтай үйлдвэрлэл эрхлэхийг;

4.1.4 "үйлдвэр" гэж түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүнд боловсруулалт хийх зориулалтын дагуу баригдсан үл хөдлөх хөрөнгө, техник, технологи, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөц, дэд бүтцийн цогцолбор бүхий аж ахуйн нэгжийг;

4.1.5 "үндэсний үйлдвэр" гэж 51 болон түүнээс дээш хувийг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж эзэмшдэг үйлдвэрийг;

4.1.6 "үнэ цэнэ шингэсэн" гэж боловсруулалтын үр дүнд тухайн бүтээгдэхүүнд нэмүү өртөг, өрсөлдөх чадвар бий болсныг

4.1.7 "бүтээгдэхүүн" гэж Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.4-д заасныг;

4.1.8 "хөнгөн үйлдвэрийн тэргүүлэх салбар" гэж Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтад багтсан үйлдвэрлэлийн салбарыг;

5 дугаар зүйл. Хөнгөн үйлдвэрлэл

5.1 Хөнгөн үйлдвэрлэлд дараах үйлдвэрлэлийг хамруулна:

5.1.1 ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

5.1.2 арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

5.1.3 мод, модон бүтээгдэхүүн, тавилга үйлдвэрлэл;

5.1.4 оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

5.1.5 сав баглаа боодлын үйлдвэрлэл;

5.1.6 гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл;

5.1.7 хэвлэлийн үйлдвэрлэл;

5.1.8 ахуйн цахилгаан бараа үйлдвэрлэл;

5.1.9 дахин боловсруулах үйлдвэрлэл.

6 дугаар зүйл. Хөнгөн үйлдвэрийг дэмжихэд баримтлах зарчим

6.1. Хөнгөн үйлдвэрийг дэмжихэд дараах зарчмыг баримтална:

6.1.1. үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагаа нь төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогод нийцсэн байх;

6.1.2. ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байх;

6.1.3. эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байх;

6.1.4. улс, бүс нутаг, дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай байх;

6.1.5. Монгол улсын бүрэн гарал үүсэлтэй бараа, бүтээгдэхүүн байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ БОЛОН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

7 дугаар зүйл. Хөнгөн үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг

7.1 Хөнгөн үйлдвэрлэл эрхлэгч дараах эрх эдэлнэ:

7.1.1 үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хамрагдах;

7.1.2 байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт техник, технологийг холбогдох хуулийн дагуу худалдан авах, эзэмших, дамжуулах;

7.1.3 үйлдвэрлэлтэй холбоотой хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзах, зохих журмын дагуу гомдол гаргах;

7.1.4 бараа, бүтээгдэхүүний гарал үүслийг буруу мэдээлж, хуурамч шошго болон албан бус гэрчилгээ ашиглаж хэрэглэгчдийг төөрөгдүүлж байгаа бусад үйлдвэрлэгчдэд хууль эрх зүйн хүрээнд шаардлага тавих, холбогдох байгууллагад мэдээлэх;

7.1.5 хуулиар олгосон бусад эрх.

7.2 Хөнгөн үйлдвэрлэл эрхлэгч дараах үүрэг хүлээнэ:

7.2.1 холбогдох хууль, журам, стандартын шаардлагад нийцсэн үйлдвэрлэлийг эрхлэх;

7.2.2 байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;

7.2.3 тогтвортой үйлдвэрлэлийг нэвтрүүлэх чиглэл баримтлах, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүндээ эрх бүхий байгууллагаар тохирлын үнэлгээ болон технологийн түвшний үнэлгээ хийлгэх;

7.2.4 хөнгөн үйлдвэрийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн журмын дагуу шаардлагатай мэдээллийг тухай бүр мэдээллийн санд бүртгүүлэх;

7.1.1 ажиллагсдын мэдлэг, туршлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ур чадварт нь тохирсон цалин урамшууллыг олгох, хуулиар тогтоосон хэмжээнээс доошгүй цалин хөлс олгох;

7.1.2 ажиллагсдын нийгмийн хамгааллын баталгааг хангах;

7.1.3 холбогдох эрх зүйн актууд болон эрх бүхий байгууллагын хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;

7.1.4 Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ гарал үүслийг үнэн зөв мэдүүлж, шошгожуулах;

7.1.5 хуулиар хүлээсэн бусад үүрэг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ, УРАМШУУЛАЛ, ХАМГААЛАЛТ

8 дугаар зүйл. Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэмжлэг, урамшуулал, хамгаалалт

8.1 Төрөөс дор дурдсан хөнгөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дэмжлэг, урамшуулал үзүүлж болно:

8.1.1 Монгол улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтад багтсан хөнгөн үйлдвэрлэлийн салбар;

8.1.2 стратегийн нөөцийн түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

8.1.3 Монгол Улсын бүрэн гарал үүсэлтэй экспортод гаргасан бэлэн бүтээгдэхүүн болон импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл;

8.1.4 эрх бүхий байгууллагын баталгаажуулсан тогтвортой үйлдвэрлэл;

8.1.5 байгалийн хоёрдогч нөөц, дахиварыг ашиглан, байгальд ээлтэй технологиор боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл.

8.1.6 холбогдох хууль, журмын хүрээнд татварын бодлогын зохицуулалтаар үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дэмжих.

8.3. Салбарын ажилтан, инженерүүдийг давтан сургаж мэргэшсэн, тэргүүлэх, зөвлөх зэрэг олгоно.

8.4. Дэмпинг, олон талт худалдаа, тогтолцооны хүрээнд зөвшөөрөгдөөгүй татаас гэх зэрэг шударга бус өрсөлдөөнөөс дотоодын үйлдвэрлэлийг Засгийн газрын баталсан холбогдох журмын дагуу хамгаална.

8.5. Тодорхой барааны импорт нэмэгдсэн, дотоодын ижил төрлийн бараа эсхүл шууд өрсөлдөх барааны үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан болон учруулах бодит эрсдэл бий болсон тохиолдолд Засгийн газрын баталсан холбогдох журмын дагуу үндэсний үйлдвэрийг хамгаална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮРЭН ЭРХ, ТӨР, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТҮНШЛЭЛ

9 дүгээр зүйл. Төрийн байгууллагын бүрэн эрх

9.1 Улсын Их Хурал нь хөнгөн үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, санхүү, татвар, зээл, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн бодлогыг тодорхойлно.

9.2 Засгийн газар нь хөнгөн үйлдвэрийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1 энэ хуулийн 8.1-т заасан дэмжлэг, урамшууллын хэлбэр, тэдгээрийг олгох журмыг батлах;

9.2.2 үйлдвэрлэлийг төрөөс дэмжихэд шаардагдах санхүүжилтийн нэмэлт хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор зохих журмын дагуу Засгийн газрын үнэт цаас гаргах, олон улсын зах зээлээс санхүүжилт олох асуудлыг шийдвэрлэх;

9.3 Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1 хөнгөн үйлдвэрлэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

9.3.2 энэ хуулийн 7.2.4-т заасан бүртгэл, мэдээллийн сангийн болон 8.3-т заасан мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах.

9.3.3 хөнгөн үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх, хөнгөн үйлдвэрийн нэгдсэн бодлогыг тодорхойлж зохицуулалтаар хангах;

9.3.4 хөнгөн үйлдвэрийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн журам батлах;

9.3.5 нутгийн захиргааны хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

9.4 Аймаг, нийслэлийн Засаг дарга хөнгөн үйлдвэрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.4.1 нутаг дэвсгэртээ хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;

9.4.2 хөнгөн үйлдвэрийн барилга байгууламжийн байршил тогтоох, газар, техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах, хөнгөн үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийг дэмжих.

10 дугаар зүйл. Төр, төрийн бус байгууллагын түншлэл

10.1 Салбарын холбоо, төрийн бус байгууллага нь дараах үйл ажиллагааг хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон төрийн зарим чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэж болно.

10.1.1 мэргэжлийн холбоод нь хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд үйлдвэр эрхлэгчтэй үйлдвэрийн талаарх төрийн бодлого, үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хамтран ажиллаж, мэдээ тайлангаа төрийн захиргааны төв байгууллагад мэдээлэх;

10.1.2 үйлдвэрлэлд тулгамдсан асуудлаар уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллаж, үнэлгээ дүгнэлт өгөх;

10.1.3 гадаад, дотоодын үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт, сургалт семинар зохион байгуулах;

10.1.4 бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд чанарын хяналт хийх, баталгаажуулалтад хамруулах, импортын барааны хяналтыг холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

10.1.5 салбарын үйлдвэрүүдэд тулгамдаж буй асуудал, саад бэрхшээл, хуулийн хэрэгжилтийн талаарх санал, хүсэлтийг холбогдох төрийн байгууллагад уламжлах;

10.1.6 Салбарын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх хүрээнд сургалт зохион байгуулж, мэргэшсэн ажилтан бэлдэх.

10.2 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, түүнийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар нь төрийн дэмжлэгтэй судалгаа хөгжлийн төвтэй байна.

10.3 Судалгаа хөгжлийн төв нь хөнгөн үйлдвэрлэлийн салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харъяанд улсын төсвөөр санхүүжиж үйл ажиллагаа явуулдаг байна.

10.4 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, түүнийг боловсруулах үйлдвэрлэлийн техник эдийн засгийн үндэслэлийг судалгаа хөгжлийн төв хүлээн авч, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн сайдын дэргэдэх эрдэмтдийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

11 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

11.1 Энэ хуулийг зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

11.2 Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

12 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

16.1. Энэ хуулийг 2022 оны .. дугаар сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

-----oOo-----